



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№175 /385/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.09.30

Цаг үе, үйл явдал

ШИЛДГИЙН ШИЛДГҮҮДДЭЭ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Үндэсний их баяр наадамд амжилт үзүүлсэн болон Цэргийн дэлхийн аварга шалгаруулах 3x3 сагсан бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцсон баг, Монголын бүх ард түмний XV их наадамд 13 дахь удаагаа тэргүүн байр эзэлсэн тамирчид, багш дасгалжуулагч нарт БХЯ-ны харьяа "Алдар" спорт хорооны хамт олон баяр хүргэж, хүндэтгэл үзүүлээ.

Хүндэтгэлийн арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, БХЯ-ны ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн хурандаа Д.Содномдаржаа, Зөвсэгт хүчний "Алдар" спорт хорооны дарга хурандаа Г.Өсөхбаяр болон албаны бусад хүмүүс оролцлоо.

Энэ үеэр "Алдар" спорт хорооны Үндэсний спортын албаны туслах дасгалжуулагч, Улсын арслан Б.Орхонбаярт дэслэгч цол олгож, амжилт гаргасан бусад баг тамирчид, дасгалжуулагч нарыг БХЯ-ны Хүндэт жуух бичиг, "Дайчин алдар" медаль, "Эх орны



төлөө" хүндэт тэмдэг, Монголын үндэсний олимпын хорооны тэргүүн дээд шагналаар шагнаж урамшуулсан юм.

Мөн олс таталт, шатар зэрэг нөхөрсөг тэмцээн зохион байгуулж "Алдар" спорт хорооны хамт олон нэгэн өдрийг хүндэтгэл,

бахархал дүүрэн өнгөрүүлээ.

Ташрамд дурдахад тус хорооны баг тамирчид Монголын бүх ард түмний XV их наадамд 13 төрлөөр амжилттай оролцсон 56 алт, 38 мөнгө, 29 хүрэл, нийт 123 медаль хүртэж 13 дахь удаагаа тэргүүн байрыг эзэлсэн юм.

Түүнчлэн тэмцээнд оролцсон 13 төрлөөс 8 төрөлд тэргүүн байр эзэлж Монгол Улсын рекорд амжилтыг буудлага, хөнгөн атлетик, хүндийг өргөлтийн төрлөөр 13 тамирчин шинэчлэн тогтоосон байна.

Х.УНДАРМАА

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 16	🌧️ 2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 30	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,515.00	3,550.00
EUR 🇪🇺	3,440.00	3,470.00
CNY 🇨🇳	480.60	484.00
RUB 🇷🇺	52.00	57.70
JPY 🇯🇵	24.25	24.60
KRW 🇰🇷	2.47	2.49

ЗУРХАЙ



2022.09.30 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 5

НАМРЫН ДУНД САРЫН ШАРАГЧИН ТАХИА САР ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ УЛААН НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Эд МАЛ АРВИДНА

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.50-18.35

БАРИЛДЛАГА:

Шид

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Мунхрахуй

Суудал: Ус

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Шүтээн босгох, хот балгадыг барих, тариа тарих, худалдаа наймаа хийх, шид бүтээл үйлдэх тарни тоолох болон дэлгэрүүлэх үйл бүхнээ сайн болой, сүм, суварга барих, хүүрийн газар эргэх, чуулан үймэхэд сайн. Нүд татваас эцэг эхэд аюул болох, баруун чих хангинавал эхнэртэй учрах, зүүн нь бол идээ ундаа олдох, нохой уливал гэнэт зочид ирэх болой. Энэ өдөр өндөр язгуурт хүний хэл ам болох, тагнай загатнавал их хүн ирэх, бие татвал хэрүүл тэмцэл болох, хөл татвал сайн.

БХЯ-НЫ ЗАХИАЛГАТ "ГАДААД ХЭЛНИЙ ДАМЖАА"-НЫ НЭЭЛТ БОЛЛОО



ҮБХИС-ийн Гадаад хэлний сургалтын төвд зохион байгуулагдаж буй БХЯ-ны захиалгат "Гадаад хэлний дамжаа"-ны нээлт ҮБХИС-ийн олон улсын хурлын "Сүбэдэй" танхимд болж өндөрлөлөө.

Нээлтийн үйл ажиллагаанд ҮАБЗ-ийн Ажлын албаны стратегийн бодлогын хэлтсийн дарга, доктор, хурандаа Р.Энхболд, ҮБХИС-ийн цэргийн алба, сургалт

хариуцсан тэргүүн дэд захирал, доктор, хурандаа Б.Энхзоргол, ҮБХИС-ийн сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, доктор, хошууч Д.Идэшноров, ҮБХИС-ийн ГХСТ-ийн дарга, дэд хурандаа М.Хонгорзул болон ГХСТ-ийн багш нар, суралцагчид оролцов.

ҮАБЗ-ийн Ажлын албаны стратегийн бодлогын хэлтсийн дарга, доктор, хурандаа Р.Энхболд, ОУУБИС-ийн гэр бүл, сэтгэл

судлалын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор Б.Оюун-Эрдэнэ нар "Гадаад хэл сурахын ач холбогдол", "Сэтгэл зүйн эрүүл мэндээ хамгаалах нь" сэдвээр тус тус лекц хэлэлцүүлгийг өрнүүлж өөрсдийн дадлага, туршлагаа алба хаагч, багш сурагчидтайгаа хуваалцсан юм.

Мөн сургалтын явцад гадаадын цэргийн сургуульд суралцахаар очиж буй цэргийн

алба хаагчид сургуульдаа очих замд тааралдаж буй хүмүүстэй хэрхэн олон хэлээр харилцаж байгааг дүрслэн үзүүлсэн нь бусад нөхдийнхөө идэвхийлэн суралцах сэдэл болж өгөв.

Энэ хичээлийн жил Батлан хамгаалахын сайдын тушаалаар нийт гадаадын 6 хэлний дамжаанд төрийн цэргийн байгууллагуудын алба хаагч нар хамрагдаж аж.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 622,545,290

Эдгэрсэн

Нийт: 602,361,215

Нас барсан

Нийт: 6,547,708

ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ АХМАДУУДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас 9 дүгээр сарын 30-ны өдөр "Олон улсын ахмадын өдөр"-ийг тохиолдуулан залуу, халуун насаа эх орноо батлан хамгаалах эрхэм үйлсэд зориулж, цэрэг дайчдыг сургаж мэргэшүүлэхэд хөдөлмөр, зүтгэлээ бүрэн зориулсан ахмад буурлуудаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлээ.

Уригдан ирсэн хүндэт зочдын хамгийн ахмад нь Зэвсэгт хүчиндээ Төрийн хүндэт харуулын анхны цэрэг гэдгээрээ алдартай чөлөөнд байгаа хошууч генерал Т.Баатар бол хамгийн залуу нь тус командлалын Цэргийн

сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн мэдээлэл, соёл хүмүүжлийн офицер, бэлтгэл дэд хурандаа Б.Золзаяа байв.

Хүндэт зочдыг Хуурай замын цэргийн штабын дарга, хурандаа Д.Дугаррагчаа тэргүүтэй удирдлагууд угтан авч, Хуурай замын цэргийнхний сүүлийн үеийн ололт амжилтаа дурдаж, гадаад харилцаа, хамтын ажиллагаа, хамтарсан болон хээрийн сургуулиуд, бэлтгэл сургалт, бэлэн байдлаа хэрхэн дээшлүүлж байгаа талаар товчхон танилцуулга хийж, ахмадуудын сонирхсон асуултад нь хариулж, "Зэвсэгт хүчин 100 жил", "Ардын хувьсгалын 100 жил"

медалиудаар шагнагдсаныг гардуулан өгч, баяр хүргэсэн юм.

Энэ үеэр зарим ахмадын сэтгэгдлийг хуваалцлаа. Чөлөөнд байгаа хошууч генерал Т.Баатар "Цэргийн галын цохилтын гол хүч нь Хуурай замын цэрэг юм. Энэ хүндтэй үүргийг биелүүлж яваа Хуурай замын цэргийнхэндээ ажлын өндөр амжилт хүсье. Миний хувьд Хуурай замын цэргийн гурвандээ сургуулийг төгсөж, гурван ч хороо командлан удирдаж явсан хүн. Хуурай замын цэрэг гэдэг миний хайртай орчин, нэршил. Жил ирэх тутам хөгжиж, бэхжиж байгаад нь сэтгэгдэл их өндөр явдаг даа.

Өнөөдөр хуучны нөхөдтэйгөө нүүр тулаад уулзахад их сайхан байна.


Жил бүр хүндэтгэн урьдаг хүүхдүүддээ "баярлалаа" гэсэн бол бэлтгэл хурандаа Д.Баярхүү "Хуурай замын цэргийн командлалд мөр зэрэгцэн алба хааж байсан нөхөдтэйгөө уулзаад их сайхан байна. Ахмадууддаа хүндэтгэл үзүүлэхийн цаад ач холбогдол нь нэгэн цагт хамтдаа алба хааж байсан нөхдийг уулзуулах байдаг. Миний хувьд 2009 онд Хуурай замын цэргийн анхны штабын даргаар томилогдож ажилласан гэдгээрээ үргэлж бахархаж явдаг юм. Зэвсэгт хүчний 38 жил

алба хаагаад 2012 онд гавьяаныхаа амралтад гарсан. Өнөөдөр манай Зэвсэгт хүчин өргөжин хөгжиж, олон улсад нь алдар суугаа цуурайтуулж яваад нь бэлтгэл офицерын хувьд баяртай байдаг. Гэхдээ энхийг сахиулах ажиллагаа нь манай цэргийнхний хоёр дахь үүрэг. Харин нэгдүгээр үүрэг нь байлдах чадвараа дээшлүүлж, бэлтгэл сургалтаа чанаржуулах тухай асуудал бөгөөд үүндээ цаашид улам илүү анхаарал тавьж ажиллаасай гэж хүсэх байна" гэлээ.

АХМАД Д.БОЛОР

Цахим шууданд

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ ТУСГАЙ ҮҮРГИЙН БЭЛТГЭЛ ШАТНЫ СУРГАЛТ ЯВАГДАЖ БАЙНА



Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын 2022 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтыг зохион байгуулж байна.

Сургалтад хамрагдаж буй бүрэлдэхүүнийг гурван хэсэгт хуваарилан Сонгинохайрхан

дүүрэг дэх Үндэсний аврах бригад, Сүхбаатар дүүргийн Аврах, гал түймэр унтраах 34 дүгээр анги, Зэвсэгт хүчний 014 ангийн материаллаг баазыг түшиглэн явуулж буй юм.

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдэд орон нутгийн хамгаалалтад

оролцох, гамшгаас хамгаалах болон хүмүүнлэгийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, улсын болон орон нутгийн бүтээн байгуулалтад оролцох талаар шаардлагатай мэдлэг, дадлага эзэмшүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн томилгоот үүргээ биелүүлэх бэлтгэлийг олгох юм.

БЭЛТГЭЛ ҮҮРЭГТНИЙ СУРГАЛТЫГ ШИНЭЛЭГ ХЭЛБЭРЭЭР...

Зэвсэгт хүчний 326 дугаар анги, нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хамтран цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг 9 дүгээр сарын 26-30-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж явууллаа.

Тус ангийн сургагч багш, сургалтын материаллаг баазыг түшиглэн явуулсан уг сургалтад цэргийн бэлтгэл үүрэгтнүүд зенитийн бага мэргэжилтнээр давтан бэлтгэгдэж, мэдлэг, дадлагаа

нэмэгдүүлж чадсан юм.

Сургалтын явцтай ЗХЖШ-ын БСТГ-ын Цэргийн дайчилгааны хэлтсийн дарга хурандаа Х.Банди, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын орлогч хурандаа Б.Эрдэнэпил нар танилцаж, үнэлэлт дүгнэлт өгөв. Энэ удаагийн цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалт нь дадлага зонхилж, цагийн байдалд ойртуулж, шинэлэг хэлбэрээр явагдсанаараа онцлог боллоо.

Ахмад Ц.Эрдмийнтуяа

ЗХЖШ АХМАДУУДАА ХҮЛЭЭН АВЛАА



Өнөөдөр ЗХЖШ-ын удирдлагууд эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг батлан хамгаалах үйл хэрэгт мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар, хөдөлмөр зүтгэл, залуу насаа зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчдаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэв.

Хүндэтгэлийн үйл ажиллагаанд ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг тэргүүтэй

бүрэлдэхүүн, алба хаагчид, ахмадууд, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нар, Төрлийн цэргийн командлалууд, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын удирдлага оролцлоо.

Энэ үеэр зарим ахмад дайчдыг Ардын хувьсгалын 100 жилийн ойн медаль, ЗХЖШ-ийн "Жуух бичиг"-ээр шагнаж урамшууллаа.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)